

## Техникийн тодорхойлолт

**1. Мах, дайвар бүтээгдэхүүнд:** Импортын бус худалдан борлуулагдахаар зөвшөөрөгдсөн бүх төрлийн мал, амьтны мах, малын гэдэс дотор, толгой, шийр орно. / Хиам болон дахин боловсруулсан бүтээгдэхүүн хамаарахгүй/

**2. Сүү, сүүн бүтээгдэхүүнд:** Импортын бус Хуурай болон шингэн сүү, тараг, аарц хамаарна.

**3. Гурил гурилан бүтээгдэхүүнд:** Импортын бус /Бялуу, кекс хамаарахгүй/

**4. Цөцгийн тос:** / Импортын бус/

**5. Төмс хүнсний ногоонд:** /Дарсан болон лаазалсан дахин боловсруулсан бүтээгдэхүүн хамаарахгүй/

**6. Будаа гэдэгт:** Бүх төрлийн будаа, хүүхдийн будаа, үр тариа, шар буурцагийн гаралтай бүтээгдэхүүн орно

**7. Ургамалын тос:**

**8. Жимс жимсгэнэ:** /Компод, жимсний чанамал, хатаасан жимс хамаарахгүй/

**Бараа бүтээгдэхүүний нийт үнийн дүн: 98.098.600**

Тендерийн нийт дүн: **98.098.600**

### Хүнсний үйлчилгээ үзүүлэх дэлгүүрт тавигдах шаардлага

- Худалдааны газрын үйлчилгээ MNS 5021:2004 улсын стандартыг мөрдөж хэвшсэн байх
- Үйлчилгээний зориулалтаар зохион байгуулсан худалдааны заалны хэмжээ 41 м2- аас багагүй байх
- Шаардлага хангасан хүнсний агуулах, зориулалтын хөргөгч, хөргүүртэй байх
- Үүдны хэсэгт тохижилт, гэрэлтүүлэгтэй энгийн хаяг тавьж зүлэгжүүлсэн байх
- Жин хэмжүүр нь баталгаажсан, хугацаа дуусаагүй байх
- Ариун цэвэр, ахуйн хангамжийн өрөө, халаалтын асуудлыг шийдсэн байх
- Худалдаалж буй барааны нэр төрөл олон, сонголт их байх
- Барааны баталгаажилт, шинжилгээний иж бүрдэлтэй байх
- Худалдагч мэргэжлийн, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд бүрэн хамрагдсан эрүүл, ажлын хувцас, энгэрийн тэмдэг, нэрийн хуудсыг зүүж хэвшсэн байх зэрэг шаардлагууд, барааны эргэлт, санхүүгийн чадавхи зэргийг харгалзан үзнэ.
- Байнгын татвар төлөгч байх
- НӨАТ-ийн суутган төлөгчөөр бүртгэгдсэн Татварын гэрчилгээтэй байх

**Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа худалдааны газрын болон нийлүүлэх нэр төрлийн бүтээгдэхүүний тус

бүрийн стандарт, мөн бүтээгдэхүүний тээвэрлэлт, сав баглаа боодлын стандартын шаардлага хангасан байна.]

**Бүтээгдэхүүн нь:** Мэргэжлийн хяналтын газрын үнэлгээ, дүгнэлттэй байх

**Байгууллага, аж ахуй нэгж нь:** Ажлын байрны үнэлгээтэй байх Е баримт хэвлэдэг машинтай байх Баталгаажсан жин хэмжүүртэй байх

**Баглаа, боодол:** 1. [Барааг хэлбэр хэмжээ, жин, ачиж буулгах, тээвэрлэх нөхцлийг цаг уурт харгалзуулан бат бөх, урагдаж эвдрэхгүй цэвэр нямбай савлаж бэлтгэн нийлүүлэх

2. Нийлүүлэгдэх барааны чанар стандартыг бүрэн хангасан байх, бараа авдаг газрын тодорхойлолт, гарал үүслийн гэрчилгээг хавсаргах

3. Буруу шошголсон хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдаалаагүй байх

4. Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгонд агуулагдах мэдээлэл монгол, орос, англи хэлний аль нэг дээр бичигдсэн байх

5. Худалдааны газар өөрөө жижиглэн савласан бол хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгын мэдээлэл нь шаардлага хангасан байх

6. Хүнсний зориулалтын сав, баглаа боодолд савласан байх

7. Зарим нэр төрлийн барааг хоёрдогч гуравдагч этгээдээс авч нийлүүлж байгаа бол хамтарлын гэрээний хуурбарыг хавсаргах]